



СЕКЮРИТИЗ
ҮЦК

2022.07.25-2022.07.29

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



2022.08.01-ний pre-trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
US30	32,717.00	-0.38%	2.67%	5.97%	-5.72%
US500	4,115.71	-0.35%	3.79%	7.63%	-6.15%
NASDAQ	12,923.00	0.20%	4.49%	11.78%	-13.66%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
GB100	7,423.00	1.06%	2.02%	3.55%	5.56%
DE40	13,484.00	1.52%	1.74%	5.48%	-13.25%
FR40	6,449.00	1.72%	3.73%	8.87%	-2.48%
IT40	22,405.00	2.16%	5.63%	5.22%	-11.66%
ES35	8,156.00	0.88%	1.30%	0.71%	-5.99%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
JP225	27,904.00	0.48%	0.74%	6.69%	0.44%
SHANGHAI	3,248.00	-0.15%	-0.13%	-4.68%	-6.30%
CSI 300	4,170.00	-0.18%	-1.11%	-7.34%	-15.56%
SHANGHAI 50	2,780.00	-0.44%	-2.05%	-8.89%	-13.46%
CH50	13,719.25	-1.35%	-2.29%	-8.38%	-8.78%
SENSEX	57,570.00	1.25%	2.67%	8.58%	9.48%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Газрын тос (Crude)	97.35	-1.23%	0.74%	0.93%	36.71%
Газрын тос (Brent)	102.87	-6.39%	2.64%	-6.04%	41.08%
Байгалийн хий	7.95	-3.55%	-8.95%	35.81%	101.94%
Шатахуун	3.08	-11.65%	-0.91%	-15.66%	35.75%
Нүүрс	407.90	-0.85%	-0.32%	5.69%	172.39%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Алт	1,760.04	-0.09%	2.43%	-2.68%	-2.91%
Мөнгө	20.16	-0.80%	9.66%	1.19%	-20.60%
Зэс	3.56	-0.66%	6.23%	1.16%	-19.68%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
АНУ	2.6631	0.0211	-0.16%	-0.28%	1.48%
Англи	1.8620	0.0040	-0.08%	-0.38%	1.30%
Швейцар	0.4590	0.0330	-0.24%	-0.57%	0.83%
Испани	1.9260	0.0460	-0.33%	-0.54%	1.72%
Португали	1.8570	0.0480	-0.33%	-0.60%	1.68%

Бодлогын хүү, ДНБ өсөлтийн мэдээ болон компаниудын тайлан гарсан чухал 7 хоног байлаа


Өнгөрсөн 7 хоногт ХНС-аас бодлогын хүүг хэдэн хувиар өсгөх, II улирлын ДНБ-ний мэдээ, өндөр үнэлгээтэй технологийн компаниудын тайлан гарсан. Хэдийгээр эдийн засгийн болон тайлангуудын мэдээнүүд тийм ч сайн биш байсан боловч хөрөнгийн зах зээл хүчтэй өсөлт үзүүлсэн нь дээрх мэдээнүүд таамагласны дагуу байсантай холбоотой байж болох юм.

Онцлох 3 мэдээнээс дурдвал:

- 1.ХНС-аас өгсөн тайлбар болон компаниудын тайлангаас харахад АНУ-ын эдийн засаг агшиж байна.
- 2.ХНС бодлогын хүүг илүү багаар өсгөж магадгүй.
- 3.Тааруухан эдийн засгийн мэдээ болон тайлан гарахаас өмнө хөрөнгийн зах зээлд аль хэдий нь ихээхэн уналт явагдсан билээ.

ХНС-ийн 7 сарын хурлаар эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж бодлогын хүүг нэмэгдүүлэхээ мэдэгдсэн

Шинжээчдийн бодлогын хүүгийн төсөөлөл



Дээрх график нь бодлогын хүүг 2023 оны 2 сард 3.5%-д хүрснээр хамгийн дээд цэгтээ хүрнэ гэж төсөөлж байна.

Шинжээчдийн таамаглаж байсны дагуу ХНС бодлогын хүүг 0.75%-иар нэмснээр бодлогын хүү 2.50%-д хүрсэн юм. ХНС-ийн ерөнхийлөгч Жером Пауэллийн хэлсэнчлэн бодлогын хүү одоо төв банкны төсөөлсөн хэмжээнд очсоноор шинжээчид үүнээс цааш илүү багаар өсөж, дараа жилээс бодлогын хүү буурч магадгүй гэж хүлээж байгаа юм.

Жером Пауэллийн мэдэгдлээс нэг анхаарал татсан зүйл нь энэ жилийн эцэс гэхэд бодлогын хүүг 3.0%-3.5% хүргэх байв. Энэ нь дараагийн 3 хурлаар 0.5%-1.0% хооронд өсгөнө гэсэн үг болж байгаа ба бодлогын хүүг өсгөх хурд саарах хандлагатайг илтгэж байна. Шинжээчид 9 сард 0.5%, 11, 12 сард 0.25%-иар тус тус өсгөнө гэсэн төсөөлөлтэй байна. Энэхүү мэдээгээр хөрөнгийн зах зээл өнгөрсөн Лхагва гарагт хүчтэй өсөлт үзүүлсэн.

Ерөнхийлөгч Жером Пауэллийн нэг онцолж хэлсэн зүйл нь бодлогын хүүг эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж өөрчилнө гэсэн. Энэ нь инфляцын түвшин ирэх саруудад хэр өсөж эсвэл буурахтай шууд холбоотой гэсэн үг. ХНС түүхий эдийн ханш унаж байгааг хүлээн зөвшөөрсөн хэдий ч эрчим хүчний үнэ Орос-Украины дайн гэх мэт гадаад хүчин зүйлээс болж хэлбэлзэлтэй байх талаар мэдэгдсэн.

Бас нэг онцолсон зүйл нь ХНС АНУ-ын эдийн засгийг хямралд орсон гэж хараахан үзэхгүй байна. ХНС-ийн мэдэгдсэнээр “АНУ-ын эдийн засаг хямралд орсон гэж зарлахын тулд хэтэрхий олон үзүүлэлтүүд тэрсэлдэж байна гэсэн юм. Жишээлбэл, ажлын байрны тоо болон ажилгүйдлийн түвшин хямралд орсон гэхэд хэтэрхий сайн хэмжээнд байна гэв.”

Инфляц болон эдийн засгийн өсөлт саарч байгаа нь засгийн газрын үнэт цаасны өгөөж буурч байгаагаас харж болох юм. 2 жилийн хугацаатай ҮЦ-ны өгөөж 6 сарын оргил цэгээсээ 0.5%-иар буурсан бол 10 жилийн хугацаатай ҮЦ-ны өгөөж 0.75%-иар буурсан юм. Энэхүү ЗГ-ын ҮЦ-ны өгөөж буурсан явдал нь хөрөнгийн зах зээл энэ сард өсөхөд хувь нэмэр их үзүүлсэн. Гэвч Edward Jones-ийн шинжээчид бодлогын хүү өссөнөөр ЗГ-ын ҮЦ-ны өгөөж дагаад өснө гэж харж байна.

АНУ-ын ЗГ-ын ҮЦ-ны өгөөж буурч байна



Дээрх графикаас харахад ХНС-ийн хурлын дараа богино болон урт хугацаат ҮЦ-ны өгөөж буурсан байна.

АНУ-ын эдийн засаг 2 улирал дараалан унаснаар хямралын дохио өгч байгаа боловч Үндэсний Эдийн Засгийн Хороо албан ёсоор зарладаг

Өнгөрсөн 7 хоногт олны анхаарлыг ихээхэн татаад байсан мэдээ бол яах аргагүй АНУ-ын ДНБ-ний өсөлтийн талаар байлаа. Энэ мэдээгээр эдийн засаг эхний хагас жилд өмнө жилийн мөн үетэй харьцуулахад 0.9% унажээ. Шинжээчдийн таамаглаж байсан 0.8%-ийн өсөлтөөс харьцангуй бага гарсан ба 2 улирал дараалан унаснаар эдийн засаг хямралд орсныг илтгэдэг билээ. Эхний улиралтай харьцуулахад өрхийн худалдан авалт 1.8%-иас 1% болон буурсан, орон сууцны хөрөнгө оруулалт 0.4%-иас огцом унаж -14% агшжээ.

II улирлын ДНБ унахад өрхийн худалдан авалт болон орон сууцны хөрөнгө оруулалт буурсантай холбоотой байжээ

Өмнөх улиралтай харьцуулахад	2022.I	2022.II
Өрхийн худалдан авалт	1.8%	1.0%
Бизнесийн хөрөнгө оруулалт	10.0%	(0.1%)
Орон сууцны хөрөнгө оруулалт	0.4%	(14.0%)
Засгийн газрын хөрөнгө оруулалт	(2.9%)	(1.9%)
Экспорт	(4.8%)	18.0%
Импорт	18.9%	3.1%
АНУ-ын бодит ДНБ	(1.6%)	(0.9%)

Эдийн засгийн хямралд орсон үгүйг албан ёсоор зарладаг газар нь Үндэсний Эдийн Засгийн Хороо (National Bureau of Economic Research) байдаг. ҮЭЗХ зүгээс “эдийн засаг хэдэн сарын турш буурахаас гадна, үйлдвэрлэл, худалдан авалт буурч, ажилгүйдлийн түвшин өссөн тохиолдолд хямрал болсон” гэж тогтоодог байна. Эдгээр үзүүлэлтүүд цаашид нэмж муудах юм бол ҮЭЗХ-оос АНУ-ыг хямралд орсонд тооцох юм байна.

Шинжээчдийн харж байгаагаар, АНУ-ын эдийн засаг хэвийн үеэс муу байхаас гадна дараагийн хэдэн сард нэмж муудах төлөвтэй байна гэж харжээ. II улирлын ДНБ-ний мэдээ нь өнгөрсөн мэдээ нь дээр тулгуурласан байдаг тул сүүлийн үеийн ХНС-ийн бодлогын хүүг өсгөсөн явдал хараахан тусгагдаагүй байгааг ойлгох хэрэгтэй.

Хатуу мөнгөний бодлогын нөлөө ойрын хэдэн сараас мэдрэгдэж эхлэх бөгөөд бодлогын хүүнд эмзэг үл хөдлөх хөрөнгийн салбар ихээхэн уналтад орохоор байна. Ажлын байр болон өрхийн худалдан авалт тогтвортой байгаа нь гүн хямралд орохоос сэргийлэхээр байна.

S&P 500 компаниудын санхүүгийн тайлан энэ хагас жилд төсөөлснөөс яльгүйхэн дээр байгаа ч жилийн эцсийн төсөөлөл буурах хандлагатай байна


Өнгөрсөн 7 хоногт гарсан компаниудын тайлан хөрөнгө оруулагчдын анхаарал татсан бас нэг мэдээ байлаа. Хэдийгээр зарим компанийн ашиг таамагласнаас бага байсан ч ихэнх компани таамагласантай тэнцүү эсвэл дээгүүр байсан. Томоохон компаниудаас дурдвал, Microsoft, Google хоёр шинжээчдийн таамагласнаас доогуур тайлан танилцуулсан боловч бизнесүүдээс олсон орлого өссөн бол өрхийн худалдан авалт буурсан байна.

S&P 500 компаниудын 55% нь тайлангаа танилцуулсан бол 72%-ийнх нь хувьцааны ханш тайлагнасны дараа өсөлт үзүүлжээ. ДНБ-ний мэдээтэй адил компанийн тайлан бас өнгөрснийг харуулдаг тул ирэх улирлуудад ашгийн төсөөлөл буурахад хөрөнгө оруулагчид бэлтгэлтэй байх хэрэгтэй. Бодлогын хүү өсөж байгаа энэ үед бизнесүүдийн ашиг жилд 8.4% өснө гэсэн төсөөлөлтэй байгаа нь 2022 оны эхээр 10% өснө гэсэн төсөөллөөс буурсан.

Хөрөнгийн зах зээл өнгөрсөн 7 хоногт өсөлт үзүүлсэн боловч ойрын хугацаанд хэлбэлзэл ихтэй байж магадгүй

Хөрөнгийн зах зээл III улирлын эхээр 8% өсөөд байгаа бол бондын өгөөж 4% өссөнөөр хөрөнгө оруулагчдын айдсыг буурахад нөлөөлөв.

2022 оны III улирлын байдлаарх өгөөж



Дээрх график нь хөрөнгийн зах зээл тогтмол өгөөжтэй зах зээлээс илүү байгааг харуулж байна.

Хэдийгээр 7 сарын сүүлээр хөрөнгийн зах зээл их өссөн ч эдийн засаг болон бизнесүүдийн ашгийн үзүүлэлт муудсанаар хэлбэлзэл их байх тул анхаарал, сэрэмжтэй байхыг сануулж байна. Хөрөнгийн зах зээл инфляцын түвшинг найдвартай буурахаас нааш хангалттай тогтмол өсөхгүй болов уу.

Иймд Edward Jones-ийн шинжээчид defensive буюу хямралын үед тэсвэртэй хувьцаанд хөрөнгө оруулж, тогтмол өгөөжтэй бонд авч багцаа бүрдүүлэхийг зөвлөж байна. Тэсвэртэй хувьцаанд эрүүл мэнд, өрхийн хэрэглээ болон хүнд үйлдвэрүүдийн хувьцааг санал болгож байгаа бол бондын хувьд зэрэглэл сайнтай, санхүүгийн хувьд найдвартай компанийн бонд авахыг зөвлөжээ.

Харин инфляц буурч, ХНС бодлогын хүүгээ өсгөхөө зогсоовол, өндөр өсөлттэй компанийн хувьцаанд хөрөнгө оруулах боломж гарна гэжээ. Урт хугацаанд хөрөнгө оруулагчид санхүүгийн хувьд чанартай, өсөлт их үзүүлэх хувьцаануудыг тэсвэртэй хувьцаанууд дээрээ нэмж авах нь оновчтой.